



“Багануур үйлдвэрлэл технологийн парк” ХК

Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн талаарх мэдээлэл.

Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/23, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/891 дугаар захирамжаар нэгж талбар 1204011855, 1203010007 дугаар бүхий, үйлдвэрлэлийн зориулалтаар 297.2 га газар эзэмшиж байсан газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонтой холбоотойгоор газар солин олгох хүсэлтийг Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсгийг үндэслэн өөр байршилд дүйцүүлэн эзэмшүүлэхээр тохиролцож байгаа бөгөөд эцэслэн шийдвэрлээгүй байна.

Мөн өөр байршилд дүйцүүлэн олгохдоо Монгол Улсын Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалт Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь “Улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт “энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ” гэж заасны дагуу Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд тухайн байршлын саналыг тусгасан бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар хүлээгдэж байна. Тус шийдвэр эцэслэсний дараа шинээр олгогдох 297,2 га газарт дахин төлөвлөлт мөн хэсэгчилсэн төлөвлөгөөний ажил шинээр хийгдэхээр байна

Мэдээлэл өгөх ажилтан:

Парк ашиглалт

төлөвлөлтийн инженер:

Э.Мөнхтөр

Утас: 80904629